

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/172/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭА-2022/172/НА-СТА-ТШЗ

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	5
3.4 Материаллаг байдал	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐3.23 № 330

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөрөнгийн тооллого хийхэд 560.8 мянган төгрөгийн мах, 450.0 мянган төгрөгийн сүү нийт 1,010.8 мянган төгрөгийн хүнсний бараа дутагдсан, хүүхдийн хоолны зардлыг нормативт хэмжээнээс 1,451.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарлагдсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, УСНББОУС 1 холбогдох заалтуудтай нийцэхгүй, бодитой оршин байх, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,432,431.22	44,126,927.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	108,412.58	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	108,412.58	-
35	БАРАА МАТЕРИАЛ	43,324,018.64	44,126,927.09
351	Түүхий эд материал	97,420.00	30,500.00
35130	Эм боох материал	97,420.00	30,500.00
354	Хангамжийн материал	43,226,598.64	44,096,427.09
35410	Бичиг хэргийн материал	735,430.00	355,280.00
35420	Аж ахуйн материал	2,110,549.95	3,699,249.95
35440	Түлш, шатах тослох материал	5,437,000.00	1,191,000.00
35460	Хүнсний материал	1,265,966.75	5,013,245.20
35470	Бусад хангамжийн материал	33,677,651.94	33,837,651.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	367,277,908.98	403,456,838.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	367,277,908.98	403,456,838.55
392	Биет хөрөнгө	336,497,908.98	372,676,838.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	320,516,700.00	366,016,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,114,039.72)	(23,463,003.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,544,354.40	40,792,854.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,737,904.11)	(26,700,188.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,660,144.78	18,660,144.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,369,067.39)	(13,077,389.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,090,450.00	11,090,450.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,290,449.84)	(2,840,449.80)
39217	Нөм	2,197,720.86	2,197,720.86
393	Биет бус хөрөнгө	30,780,000.00	30,780,000.00
39301	Програм хангамж	50,000.00	50,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(50,000.00)	(50,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,780,000.00	30,780,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	410,710,340.20	447,583,765.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	751,887.80	779,619.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	751,887.80	779,619.39
413	Өглөг	751,887.80	779,619.39
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	634,007.00	779,619.39
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	96,880.80	-
4136	Бусад өглөг	21,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	21,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	409,958,452.40	446,804,146.25
51	Засгийн газрын хувь оролцоо	450,745,530.54	450,745,530.54
512	Хуримтлагдсан үр дүн	(170,835,615.93)	(133,989,922.08)
51210	Өмнөх үеийн үр дүн	(170,835,615.93)	(170,835,615.93)
51220	Тайлант үеийн үр дүн	-	36,845,693.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,048,537.79	130,048,537.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	410,710,340.20	447,583,765.64

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгсгөрөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	251,154,950.00	281,386,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,266,550.00	50,929,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,266,550.00	50,929,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,266,550.00	50,929,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,266,550.00	50,929,500.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,888,400.00	230,457,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	226,969,200.00	211,423,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	226,969,200.00	211,423,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	113,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	113,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,919,200.00	18,920,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,919,200.00	18,920,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	243,842,102.96	244,540,906.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	243,842,102.96	244,540,906.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213,450,240.54	216,527,871.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,314,728.00	158,954,752.00
210101	Үндсэн цалин	104,573,034.00	114,491,853.00
210102	Нэмэгдэл	25,666,866.00	7,926,734.00
210104	Урамшуулал	10,159,628.00	18,301,922.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,915,200.00	18,234,243.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,043,855.00	21,425,246.00
210201	Тэтгэврийн даатгал	12,949,824.00	15,015,228.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,523,508.00	1,570,536.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,218,807.00	1,298,708.54
210204	Ажилгүйдлийн даатгал	304,700.00	342,814.91
210205	Эрүүл мэндийн даатгал	3,047,016.00	3,197,958.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,806,180.00	11,287,920.23
210301	Гэрэл, цахилгаан	3,262,227.00	3,052,920.08
210302	Түлш, халаалт	9,152,400.00	7,905,000.15
210303	Цэвэр, бохир ус	391,553.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,795,550.00	3,487,249.85
210401	Бичиг хэрэг	2,239,300.00	1,509,150.00
210402	Гэвэр, шатахуун	609,500.00	299,999.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	31,900.00
210404	Ном, хэвлэл	36,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	585,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,040,750.00	1,406,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,285,000.00	-
2105	Нормативт зардал	11,100,685.70	5,575,432.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	258,750.00	97,420.00
210502	Хоол, хүнс	10,148,835.70	5,478,012.75
210503	Нормын хувцас, зөөлөн эднэл	693,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,387,100.00	121,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	270,900.00	-
210604	Урсгал засвар	1,116,200.00	121,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,678,141.84	15,352,270.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	837,500.00	782,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,840,641.84	14,569,570.43

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,391,862.42	28,013,034.89
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,141,862.42	11,272,079.92
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	2,012,420.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,129,442.42	11,272,079.92
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		16,440,954.97
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		16,440,954.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,312,847.04	36,845,693.85
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7,312,847.04	36,845,693.85

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,745,530.54	130,048,537.79	(178,148,462.97)	402,645,605.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,745,530.54	130,048,537.79	(178,148,462.97)	402,645,605.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	7,312,847.04	7,312,847.04
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,745,530.54	130,048,537.79	(170,835,615.93)	409,958,452.40
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	450,745,530.54	130,048,537.79	(170,835,615.93)	409,958,452.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,745,530.54	130,048,537.79	(170,835,615.93)	409,958,452.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	36,845,693.85	36,845,693.85
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,745,530.54	130,048,537.79	(133,989,922.08)	446,804,146.25

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021оны 12-р сарын 31

/Төрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	245,888,400.00	230,457,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,888,400.00	230,457,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	226,969,200.00	211,423,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	226,969,200.00	211,423,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	113,700.00
131104	Доод шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	113,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,919,200.00	18,920,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,919,200.00	18,920,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	245,888,400.00	230,457,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,888,400.00	230,457,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,346,537.58	202,444,065.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,780,028.00	159,232,813.74
210101	Үндсэн цалин	97,956,352.00	107,145,938.74
210102	Нэмэгдэл	29,186,955.00	25,018,283.00
210104	Урамшуулал	9,251,160.00	10,685,095.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,385,561.00	16,383,497.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,160,583.58	20,893,159.29
210201	Тэтгэврийн даатгал	11,669,188.59	14,634,341.61
210202	Тэтгэмжийн даатгал	1,339,693.76	1,540,296.11
210203	ҮОМПӨ-ний даатгал	1,131,437.40	1,260,908.54
210204	Ажил үйлдлийн даатгал	274,568.36	335,254.91
210205	Эрүүл мэндийн даатгал	2,745,695.47	3,122,358.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,421,580.00	7,041,920.08
210301	Гэрэл, цахилгаан	3,262,227.00	3,052,920.08
210302	Түлш, халаалт	12,767,800.00	3,659,000.00
210303	Цэвэр, бохир ус	391,553.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,969,300.00	2,855,800.00
210401	Бичиг хэрэг	1,054,300.00	53,000.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	31,900.00
210404	Ном, хэвлэл	21,000.00	33,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	585,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзгдэх, ахуйн эд зүйлс	4,009,000.00	2,197,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
2105	Нормативт зардал	9,119,646.00	9,664,672.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	359,600.00	30,500.00
210502	Хоол, хүнс	6,832,946.00	9,343,172.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,927,100.00	291,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,485,200.00	606,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	485,200.00	606,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,086,200.00	1,825,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,086,200.00	1,825,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,541,862.42	28,013,034.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,141,862.42	11,272,079.92
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	2,012,420.00	-

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,129,442.42	11,272,079.92
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		16,440,954.97
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		16,440,954.97
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,343,400.00	202,630,365.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230,043,400.00	202,330,365.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,142,900.00	159,232,813.74
210101	Үндсэн цалин	100,046,500.00	107,145,938.74
210102	Нэмэгдэл	40,809,700.00	25,018,283.00
210104	Урамшуулал	10,685,100.00	10,685,095.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,601,600.00	16,383,497.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,564,500.00	20,893,159.29
210201	Тэтгэврийн даатгал	15,878,600.00	14,634,341.61
210202	Тэтгэмжийн даатгал	1,671,500.00	1,540,296.11
210203	ҮОМШО-ний даатгал	1,337,200.00	1,260,908.54
210204	Ажилгүйдлийн даатгал	334,300.00	335,254.91
210205	Эрүүл мэндийн даатгал	3,342,900.00	3,122,358.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,435,000.00	7,041,920.08
210301	Гэрэл, цахилгаан	4,900,000.00	3,052,920.08
210302	Тулш, халаалт	12,835,000.00	3,659,000.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,569,300.00	2,742,100.00
210401	Бичиг хэрэг	54,300.00	53,000.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,000.00	31,900.00
210404	Ном, хэвлэл	33,200.00	33,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ари	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	197,800.00	2,084,000.00
2105	Нормативт зардал	17,560,900.00	9,664,672.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,500.00	30,500.00
210502	Хоол, хүнс	17,237,300.00	9,343,172.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	293,100.00	291,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	485,200.00	606,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	485,200.00	606,200.00
2107	Томилголт, зочны зардал	55,500.00	-
210702	Дотоод албан томилголт	55,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,906,100.00	1,825,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,600.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,825,500.00	1,825,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	230,343,400.00	202,630,365.11
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	211,423,200.00	194,982,245.03
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	211,423,200.00	194,982,245.03
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,920,200.00	7,648,120.08
132001	Орон нутгийн төсвөөс	18,920,200.00	7,648,120.08

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	113,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	113,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	113,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
2104	Хангамж, бараа материалын зардал	-	113,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	113,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	113,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	113,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	113,700.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор Б.Баярмаа, аудиторын туслах Б.Мөнхзул нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт тосгоны Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаа сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 243,842.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,438.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,950.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,873.4 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	108.4	-	(108.4)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,324.0	44,126.9	802.9
Үндсэн хөрөнгө	367,277.9	403,456.8	36,178.9
Нийт хөрөнгө	410,710.3	447,583.7	36,873.4
Өр төлбөр	751.9	800.6	48.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	450,745.5	450,745.5	-
Хуримтлагдсан үр дүн	(170,835.6)	(134,010.9)	36,824.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,048.5	130,048.5	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	410,710.3	447,583.7	36,873.4

Бараа материалын дансны үлдэгдэл нь 44,126.9 мянган төгрөг болж 802.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 17,317.7 мянган төгрөгийн бараа материал

ХЭА-2022/172/НА-СТА-ТШЗ

худалдан авч 16,695.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 403,456.8 мянган төгрөг болж 36,178.9 мянган төгрөгөөр өссөн нь 45,500.0 мянган төгрөгийн дээврийн их засварын зардлаар барилгыг капиталжуулж, тоног төхөөрөмж дансанд үнэ төлбөргүй орлого 5,248.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 14,569.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хорогджээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 134,010.9 мянган төгрөг болж, 36,824.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлсөн байна..

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 30,210.7 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 50,748.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 698.8 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт их хэмжээгээр гараагүй

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 369,943.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 139,599.6 мянган төгрөгөөр бууруулан нийт зарлагыг 230,343.4 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,612.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 17,303.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,200.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 18,241.4 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 230,343.4 мянган төгрөгөөр баталсанаас 211,423.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 18,920.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 211,423.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 18,920.2 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 202,630.4 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 16,440.9 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 11,272.1 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 202,630.3 мянган төгрөг буюу 87.9 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 7,910.0 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 7,894.1 мянган

төгрөгөөр, байр ашиглалтын тогмол зардал 11,393.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 113,7 мянган төгрөгийн орлого орж, 113,7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх онд аудитаар 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 48,744.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 45,500.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,462.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 782.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Дээврийн их засварын 45,500.0 мянган төгрөгийг бүртгээгүй байсныг залруулж барилгын өртөгт шингээн капиталжуулж санхүүгийн тайланд залруулга хийлээ.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Өмнөх онд нэр бүхий 2 иргэнд мах, сүүний үнэнд 1,010.8 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч 2 жил дараалан орлогод аваагүй, нягтлан бодох бүртгэлд авлагаар тусгаж тайлагнаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэлд бодитоор байгаа мэтээр тусгасан.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.2.2 Тайлант онд 1 хүүхдэд ногдох хоолны зардлыг нормативаас 1,451.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт:

4.4.1. Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 782.7 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллаг ын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардла га		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Өлзийт тосгоны цэцэрлэг	4	48,744.6	1	45,500.0	2	2,462.0			1	782.7
	Дүн	4	48,744.6	1	45,500.0	2	2,462.0			1	782.7



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 34/23910610
ХЭА-2022/172/НА-ТА-ТНЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд нийт 1 хүүхдэд ногдох хоолны зардлыг нормативаас 1,451.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 тоот тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2,475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Норматив хэтрүүлж зарцуулсан 1,451.6 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өлзийт тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Г.Ариунцэцэг, нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 35/23910610
ХЭА 2022/172/НА-ТА-ТШЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Өмнөх онд нэр бүхий 2 иргэнд мах, сүүний үнэнд 1,010.8 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч 2 жил дараалан орлогод аваагүй, нягтлан бодох бүртгэлд авлагаар тусгаж тайлагнаагүй, тайлант онд жилийн эцсийн тооллогын бүртгэлд бодитоор байгаа мэтээр тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутагдсан 1,010.8 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өлзийт тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Г.Ариунцэцэг, нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА